



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2024. 06. 13 № 7/2596
танай _____ -ны № _____ -т

Г ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАРТ

Тус яаманд ирүүлсэн 2024 оны 05 дугаар сарын
16-ны өдрийн 01/900, 05 дугаар сарын 22-ны өдрийн
01/974 дугаартай албан бичгүүдийн дагуу Эрүүл
мэндийн сайдын тушаалд өөрчлөлт орсныг
хавсралтаар хүргүүлж байна.

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН
ДАРГА *Л.Лувсан* Л.ЛУВСАН

1119270972 0087443

146241915

ХАВСРАЛТ:

"Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/"
ЭМЯ/20240102083 дугаартай цахим тендерт оролцогч байгууллагуудад дараах тодруулгыг хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Өөрчлөлт
1	<p>Гантри</p> <ul style="list-style-type: none"> - Орны урагшлах дээд хурд: 300 мм/с - Дахин боловсруулалтын хурд: 80 fps-ээс багагүй <p>Рентген хоолой</p> <ul style="list-style-type: none"> - Гүйдлийн хэмжээ: 5mA-667mA - Хоолойн хүчдэл кВ: 70kV-140kV 	<p>Гантри</p> <ul style="list-style-type: none"> - Орны урагшлах дээд хурд: 250-300 мм/с байх - Дахин боловсруулалтын хурд: 55 fps-ээс багагүй <p>Рентген хоолой</p> <ul style="list-style-type: none"> - Гүйдлийн хэмжээ: 5mA-660mA байх эсвэл дүйцэхүйц - Хоолойн хүчдэл кВ: 70kV-140kV байх эсвэл дүйцэхүйч
2	<p>ТШЗ 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Цаг: 11 цаг 00 минут</p>	<p>ТШЗ 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн Цаг: 11 цаг 00 минут</p>
3	<p>ТШЗ 26.2. Тендерийн нээх хугацаа:</p> <p>Огноо: 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Цаг: 11 цаг 40 минут</p>	<p>ТШЗ 26.2. Тендерийн нээх хугацаа:</p> <p>Огноо: 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн Цаг: 11 цаг 40 минут</p>



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@afccp.gov.mn,

Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.16 № 01/900

танай _____ -ны № _____ -т

Тендер түдгэлзүүлэх тухай


Танай үйлдвэрээс зарласан “Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/” ЭМЯ/20240102083 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Сакура Медикал” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалгчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Тус газарт тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад холбогдох шаардлагатай баримт бичгийг албан бичгээр болон цахим шуудангаар (nominerdene@afccp.gov.mn) 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА

Б.БИЛГҮҮН



001880



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.22 № 01/974
танай _____ -ны № _____ -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯМАНД

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай яамнаас зарласан “Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/” ЭМЯ/20240102083 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Сетунари” ХХК болон “Сакура мэдикал” ХХК-удаас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хяналаа.

1. Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод “1. Компьютер томографийн аппарат /64 зүслэгтэй/ “Гантри: орны урагшлах дээд хурд: 300 мм/с, дахин боловсруулалт хурд: 80 fps-ээс багагүй, Рентген хоолой: гүйдлийн хэмжээ 5mA-667mA, хоолойн хүчдэл kB 70kB-140kB” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайллан заахыг хориглоно” гэж, 12.5-д “Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа тодорхой нэг бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайллан заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.


2. Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “Багц 1: Компьютерт томографийн аппарат /64 зүслэгтэй/-ийн хувьд төслийг хэрэгжүүлэх 2-оос доошгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй байх бөгөөд чадвар, мэргэжлийг илтгэх боловсролын

0002027

диплом, үнэмлэх, үйлдвэрлэгчийн сургалтад хамрагдсан сертификат, бусад холбогдох бичиг баримтын хуулбарыг ирүүлнэ” гэж заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Захиалагч техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно” гэж, 17.2.3-т “гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл” гэж тус тус заасны дагуу боловсруулсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.



ДАРГА

Б.БИЛГҮҮН